

19.12. Анги, танхимын мэдээлэл импортлох

Анги, танхимын мэдээллийг эксел файл дээр бэлдэж татах боломжтой. Импортлох эксел файлын загвар нь системийн **Дата импорт ->Анги, танхим-> Загвар татах -> FacilityImportTemplate.xlsx** гэсэн нэртэй файл байна.

ДБУМСТуршилтын интерпрайз

Дата импорт

Мэдээллийн төрөл

Анги, танхим

Загвар татахИмпорт датаХуулахУстгахExcel-рүү гаргах

Төлөв	Тайлбар	Мөр	Процесс	Сургалтын байгууллагын код	Байрны код	Анги танхимын төрөл	Анги танхимын код	Анги танхимын нэр	Анги танхимын тайлбар
✓	Хуулагдсан	31	2020/01/17 15:15:13 (100000040511553)	1	аааа	Ариун цэврийн ...	01-031	Танхимын нэр 31	тайлбар 31
✓	Хуулагдсан	32	2020/01/17 15:15:13 (100000040511553)	1	аааа	Бусад өрөө	01-032	Танхимын нэр 32	тайлбар 32
✓	Хуулагдсан	33	2020/01/17 15:15:13 (100000040511553)	1	аааа	Номын сан	01-033	Танхимын нэр 33	тайлбар 33
✗	Байр бүртгэгдээгүй байна.	34	2020/01/17 15:15:13 (100000040511553)	1	002	Чөлөөт цаг өнг...	002-001	Танхимын нэр 34	тайлбар 34

Хуудас 33-с (34-с 31-34 байна) К < 1 2 3 > X

2018 © Бүх эрх хуулиар хамгаалагдсан. БСШУСЯ

Өмнөх нөхцөл

- Сургалтын байгууллага идэвхтэй төлөвтэй байна.
- Байрны мэдээлэл үүссэн байх.

Зөвлөмж

- Тоо төрлийн талбарт зөвхөн тоон утга оруулна.
- Огноо төрлийн талбарт он-сар-өдөр форматаар оруулна.
- Текст төрлийн талбарт тоо, үсэг, тэмдэгтээс бүрдсэн мэдээлэл оруулна.
- Ганц сонголт талбарт өгөгдсөн ангиллаас нэгийг сонгоно.
- Заавал бөглөх талбарын өгөгдлийг оруулсан байх.
- Тухайн мэдээлэл дэх код, нэрийг давхцуулахгүйгээр оруулах

Файлын баганын мэдээлэл

Баганы нэр	Төрөл	Тайлбар	Заавал бөглөх талбар эсэх
Сургалтын байгууллагын код	Тоо	Сургалтын байгууллагын кодыг оруулна. Энэ нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд сургалтын байгууллагыг давхцахгүй байдлаар кодолсон код	Заавал

		юм. Систем тухайн кодоор сургалтын байгууллагыг танина. Код буруу оруулсан тохиолдолд алдаа заана. Сургалтын байгууллагын кодыг Систем > Манай байгууллага > Ерөнхий мэдээлэл таб > Үндсэн мэдээлэл хэсэг > Код талбараас харна уу!	
Байрны код	Текст	Тухайн анги танхимын байрлах байрны кодыг оруулна. Сургалтын байгууллагын кодыг Систем > Сургалтын орчин>Байр>Байрны код хэсгээс харна уу!	Заавал
Анги танхимын төрөл	Ганц сонголт	Анги, танхимын төрлөөс тохирох төрлийг сонгоно. Төрлийг зөв сонгох шаардлагатай. Дараа нь тайлан гаргахад энд сонгосон төрлийн дагуу тоологдоно.	Заавал
Анги танхимын код	Текст	Анги танхимын кодыг давхцахгүй байдлаар оруулна.	Заавал
Анги танхимын нэр	Текст	Анги танхимын нэрийг давхцахгүй байдлаар оруулна.	Заавал
Анги танхимын тайлбар	Текст	Анги танхимын талаар дэлгэрэнгүй тайлбар бичих боломжтой.	Нэмэлт
Анги танхимын багтаамж	Тоо	Анги, танхимын стандарт багтаамжыг оруулна. Хэмжих нэгж нь суудлын тоо буюу хүн байна.	Нэмэлт
Анги танхимын давхар	Тоо	Анги, танхимын байрлах давхрыг оруулна.	Нэмэлт
Өрөөний дугаар	Текст	Анги, танхимын албан ёсны тоот-ыг оруулна.	Нэмэлт
Ашиглаж байгаа эсэх	Текст	Анги, танхимыг одоо идэвхтэйгээр ашиглаж байгаа эсэх талаар тэмдэглэнэ.	Нэмэлт
Ашиглаж эхэлсэн огноо	Огноо	Анги, танхимыг ашиглаж эхэлсэн огноог оруулна.	Заавал